



**ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2022 оны 09 сарын 15 өдөр

Дугаар 11/02

Эрдэнэт


Аймгийн 2021 оны төсвийн гүйцэтгэл
батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1.9 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Аймгийн 2021 оны төсвийн орлогын гүйцэтгэлийг 80 019 043 600 (наян тэрбум арван есөн сая дөчин гурван мянга зургаан зуун) төгрөгөөр, зарлагын гүйцэтгэлийг 61 219 254 100 (жаран нэгэн тэрбум хоёр зуун арван есөн сая хоёр зуун тавин дөрвөн мянга нэг зуун) төгрөгөөр, төсвийн хэмнэлтийг 8 054 541 300 (найман тэрбум тавин дөрвөн сая таван зуун дөчин нэгэн сая гурван зуун) төгрөгөөр, давсан орлогыг 10 745 248 200 (арван тэрбум долоон зуун дөчин таван сая хоёр зуун дөчин найман мянга хоёр зуун) төгрөгөөр тус тус баталсугай.

2.Төсвийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, төсвийн зарцуулалтын үр ашиг, зохистой байдлыг хангаж ажиллахыг аймгийн Засаг дарга (С.Батжаргал)-д даалгасугай.

ДАРГА



Д. МӨНХБАТ